

Мөрөөдлөө
Санхүүжүүл

InvesCore
САНХҮҮГИЙН ГРУПП

**ИНВЕСКОР ББСБ ХК
2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Агуулга

Гол амжилтууд	1
Компанийн бүтэц	2
Зээлийн үйл ажиллагаа	3
Борлуулалтын суваг	4
Покет - Дижитал зээл	5
ЖДҮ дэмжих хөтөлбөр	6
Олон улсын зах зээл	7
ISO СТАНДАРТ	8
Санхүүгийн үр дүн	9
Зохистой харьцааны үзүүлэлт	10
Хувьцааны үзүүлэлт	11

ГОЛ АМЖИЛТУУД



Чанарын удирдлага (**ISO9001**) болон мэдээллийн аюулгүй байдлын (**ISO27001**) стандартыг нэвтрүүлээ.

1.8 тэрбум төгрөг

Нэгж хувьцаанд 25 төгрөг буюу нийт **1.8 тэрбум** төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч нартаа тараахаар боллоо.




Нидерланд улсын Краудфандинг платформ болох "Hands-on B.V." компаниас **2.5 сая ам.доллар** татах хэлэлцээр хийлээ.

КОМПАНИЙН БҮТЭЦ



ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Зээлийн багц, харилцагчийн тоо




✓ Зээлийн багц өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 102 хувиар өсч 219 тэрбум төгрөг, харилцагчийн тоо 104 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зээлийн багц (бүтээгдэхүүнээр %)



Зээлийн багцын чанар

■ Чанаргүй
■ Хугацаа хэтэрсэн



БОРЛУУЛАЛТЫН СУВАГ



18 салбар

Инвескор ББСБ ХК нь Монгол Улсад нийт 18 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2022 онд шинээр 4 салбар нээхээр төлөвлөж байна.

Байршил

Үүнээс 16 нь Улаанбаатар хотод, 1 нь Эрдэнэт хотод, 1 нь цахим хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.





4 аймаг

Инвескор Аллианс төсөл нь Монгол улсын 4 аймаг тус бүрт гишүүн ББСБ-тай бөгөөд 2022 онд нэмж 6 аймагт гишүүн элсүүлнэ.

ПОКЕТ - ДИЖИТАЛ ЗЭЭЛ

2021 онд Покет платформ нь "Цахим зээлийн төв" болж бусад санхүүгийн байгууллагуудад өөрийн технологийн шийдэл, бусад давуу талуудаа санал болгож эхэлсэн. 2022 онд нийт 4 санхүүгийн байгууллагыг Цахим зээлийн төв-д элсүүлэхээр төлөвлөснөөс 1 байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлж цахим зээлийн бүтээгдэхүүнийг нь Покет платформд бүрэн нэвтрүүлээд байна.

Гол Бүтээгдэхүүн, Үйлчилгээ

 <p>44.6 тэрбум төгрөгийн зээлийн багцтай, 200 мянган идэвхтэй зээл</p>	 <p>Цахим төлбөр тооцооны 500 мянга + бүртгэлтэй хэрэглэгч</p>	 <p>220+ нэр төрлийн купон, 180+ хамтрагч байгууллага</p>	 <p>300+ Мерчант байгууллага, 300+ Брэнд, 500+ салбар</p>
<p>Pocket Loan</p>	<p>Pocket Pay</p>	<p>Pocket Coupon</p>	<p>Pocket Zero</p>

Нийгмийн хариуцлага

Pocket хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй "Тэнцвэр" аяныхаа хүрээнд өнөөдөр Нийслэлийн хот тохижилтын газартай хамтран Сөүлийн гудамжны (Төмөр замын дээд сургуулиас 1-р сургуулийн уулзварыг дуустал ойролцоогоор 300 орчим мод) замын 2 талын бүх улиас модыг оохордож будах ажлыг хийлээ.

Улиас модыг оохордож будсанаар хортон шавьжаас сэргийлэх, ургалтыг нь дэмжих, хотын өнгө үзэмжийг нэмэх гээд олон давуу талтай юм.


Оффисын эргэн тойронд агаарын бохирдлыг бууруулж, цэвэр агаарын "тэнцвэр"-ийг хадгалж байгаа моднуудаа хортон шавьжаас хамгаалах ажилд гар бие оролцсондоо бид бүхэн баяртай байна.



ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Ковид-19 цар тахлын үед Монгол улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг “Инвескор ББСБ” ХК нь “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

НИЙТ ХАРИЛЦАГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



- Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
- Эмэгтэй бизнес эрхлэгч
- Хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгч
- Байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
- Өрх толгойлсон эцэг/эхийн бизнес

2022 оны 1 дүгээр улирлын байдлаарх үр дүн

- ✓ 2.3 тэрбум төгрөгийн зээл олголт
- ✓ 91+ ААН болон иргэн
- ✓ 300+ ажлын байр хадгалсан
- ✓ Нийт харилцагч нарын 85% нь үйлдвэрлэл эрхэлдэг

Зээлдэгчид тавигдах шаардлага

- ✓ Үйлдвэрлэл үйлчилгээний бизнес эрхэлдэг байх;
- ✓ Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлдэг байх;
- ✓ 6 сар ба түүнээс дээш хугацаагаар идэвхтэй үйл ажиллагаа явуулсан байх

ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

30 сая хүртэл

Нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ

4.8 Хувь

Зээлийн жилийн хүү

24 сар хүртэл

Зээлийн хугацаа

0.0 Хувь

Зээл судалсны шимтгэл

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

Инвескор ББСБ ХК нь олон улсад зах зээлээ тэлэх стратегийн хүрээнд Киргиз улсад 2 охин компани ("Invescore CA" MFC, "Pocket KG" LLC) байгуулсан бөгөөд үйл ажиллагаа нь хурдацтай тэлж, өргөжиж байна.

"INVESCORE CA" MFC

Компани нь 30 ажилтан, 4 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 оны 1-р улиралд нийт 3 тэрбум орчим төгрөгийн зээл олголт хийсэн бөгөөд нийт олголтын 60 хувийг жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгожээ.

2022 оны 1 дүгээр улирлын үр дүнг өмнөх онтой харьцуулахад:

- ✓ Зээлийн багц 7.6 тэрбум төгрөгт хүрч 133%-иар өссөн.
- ✓ Нийт хөрөнгө 9.2 тэрбум төгрөгт хүрч 163%-иар өссөн.
- ✓ Хугацаа хэтэрсэн зээлийн хувь 1.9%, Чанаргүй зээлийн хувь 0.9%-тай байна.
- ✓ Нийт зээлийн тоо 915-т хүрч 168%-иар өссөн.



"POCKET KG" LLC

Компани нь Монгол улсын зах зээлд тэргүүлж буй цахим хэтэвч, дижитал зээлийн Покет платформыг Киргиз улсын зах зээлд нийцүүлэн өөрчилж, нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

2022 оны 1-р улирлын байдлаар системийн хөгжүүлэлт, төрийн байгууллауудын холболт, аппликейшний туршилт зэрэг ажлууд амжилттай хийгдэж дууссан бөгөөд 2-р улиралд бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх маркетинг, борлуулалтын ажлууд үе шаттайгаар хийгдэнэ.



ОЛОН УЛСЫН СТАНДАРТ 9001&27001

ISO 9001 ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ГЭЖ ЮУ ВЭ?

- ✓ ISO 9001 нь дэлхийн 178 орны 1,064,000 байгууллагад хэрэгжсэн байдаг ба удирдлагын тогтолцооны хамгийн түгээмэл стандарт юм. Тус стандарт нь бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг төлөвлөлтөөс бодит болгох хүртэлх бүх үе шатыг системтэй удирдахад чиглэгддэг.

"ИНВЕСКОР ББСБ" ХК ISO 9001 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛСЭНЭЭР:

- ✓ Харилцагчдадаа үзүүлж буй үйлчилгээний чанараа сайжруулах;
- ✓ Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн болон холбогдох хуулийн зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг тууштай үзүүлэх чадвараа нэмэх;
- ✓ Харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх;
- ✓ Урт удаан хугацаанд өрсөлдөхүйц хурдтай, үр ашигтай ажиллах;
- ✓ Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн
- ✓ Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын шаардлагуудад нийцсэн



ISO 27001 ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ГЭЖ ЮУ ВЭ?

- ✓ Инвескор ББСБ ХК нь хамтран ажиллагч байгууллага, харилцагчдынхаа мэдээллийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг найдвартай хангах үүднээс Мэдээллийн Аюулгүй Байдлын Удирдлагын Тогтолцоог амжилттай нэвтрүүлж, ISO/IEC 27001:2013 олон улсын стандартын батламжийг авсан анхны ББСБ болж байна.

"ИНВЕСКОР ББСБ" ХК ISO 27001 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛСЭНЭЭР:

- ✓ Харилцагч, хамтрагч байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг системтэйгээр хангах, тасралтгүй сайжруулах дотоод тогтолцоог бий болгох;
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон улсын болон дотоодын хууль тогтоомжид нийцэх;

САНХҮҮГИЙН ҮР ДҮН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ /мянган ₮/

2021.I

2021

2022.I

	2021.I	2021	2022.I
		<i>Аудитлагдсан</i>	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	14,856,598	24,638,751	18,869,404
Хөрөнгө оруулалт	1,854,533	183,583	1,267,780
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	113,213,297	175,508,816	221,886,805
<i>Нийт зээл</i>	<i>108,499,547</i>	<i>173,192,374</i>	<i>219,211,860</i>
<i>Эрсдэлийн сан</i>	<i>2,661,444</i>	<i>3,146,865</i>	<i>(4,192,487)</i>
<i>Хүүний авлага</i>	<i>7,375,194</i>	<i>5,463,307</i>	<i>6,867,432</i>
<i>Авлага</i>	<i>4,630,054</i>	<i>3,274,706</i>	<i>8,951,007</i>
<i>Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө</i>	<i>375,226</i>	<i>783,568</i>	<i>2,617,649</i>
<i>Бусад актив</i>	<i>1,088,515</i>	<i>1,980,060</i>	<i>1,566,332</i>
<i>Үндсэн ба биет бус хөрөнгө</i>	<i>9,013,472</i>	<i>5,852,811</i>	<i>4,912,433</i>
Нийт хөрөнгийн дүн	145,031,694	212,222,295	260,071,410
<i>Итгэлцлийн үйлчилгээний өглөг</i>	<i>38,240,646</i>	<i>56,477,725</i>	<i>59,201,888</i>
<i>Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл</i>	<i>18,744,766</i>	<i>34,396,459</i>	<i>49,539,802</i>
<i>Бонд</i>	<i>7,760,000</i>	<i>27,620,907</i>	<i>29,457,000</i>
<i>Бусад өглөг</i>	<i>25,624,906</i>	<i>18,210,441</i>	<i>38,677,755</i>
Нийт өр төлбөрийн дүн	90,370,318	136,705,532	176,876,445
<i>Хувьцаат капитал</i>	<i>16,282,237</i>	<i>16,282,237</i>	<i>16,282,237</i>
<i>Нэмж төлөгдсөн капитал</i>	<i>15,377,738</i>	<i>15,377,738</i>	<i>15,377,738</i>
<i>Хоёрдогч өглөг</i>	<i>-</i>	<i>4,972,070</i>	<i>5,000,000</i>
<i>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</i>	<i>23,001,401</i>	<i>38,884,718</i>	<i>46,534,990</i>
Нийт өөрийн хөрөнгө	54,661,376	75,516,763	83,194,965
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	145,031,694	212,222,295	260,071,410

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ /мянган ₮/

2021.I

2021


2022.I

	2021.I	2021	2022.I
Хүү болон түүнтэй адилтгах орлого	7,155,004	41,122,071	13,668,502
Хүү болон түүнтэй адилтгах зардал	2,551,224	12,814,237	4,598,662
<i>Бусад хүүгийн зардал</i>	<i>861,989</i>	<i>5,336,908</i>	<i>2,398,588</i>
<i>Итгэлцлийн үйл ажиллагааны зардал</i>	<i>1,689,235</i>	<i>7,477,329</i>	<i>2,200,074</i>
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	(15,216)	743,455	61,354
Хүүгийн цэвэр орлого	4,618,997	27,564,379	9,008,486
<i>Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого</i>	<i>1,432,380</i>	<i>8,886,652</i>	<i>3,314,505</i>
<i>Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, зардал</i>	<i>563,519</i>	<i>(157,173)</i>	<i>73,808</i>
Нийт хүүгийн бус цэвэр орлого	1,995,898	8,729,479	3,388,313
Нийт үйл ажиллагааны орлого	6,614,895	36,293,858	12,396,799
<i>Ажиллагсадтай холбогдолтой зардал</i>	<i>1,326,053</i>	<i>5,759,249</i>	<i>2,409,121</i>
<i>Үйл ажиллагааны бусад зардал</i>	<i>1,947,683</i>	<i>6,455,882</i>	<i>2,147,747</i>
Нийт үйл ажиллагааны зардал	3,273,736	12,215,131	4,556,868
<i>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)</i>	<i>(358,885)</i>	<i>(368,409)</i>	<i>160,498</i>
Татварын өмнөх ашиг	2,982,274	23,710,318	8,000,430
<i>Орлогын албан татвар</i>	<i>301,095</i>	<i>4,518,782</i>	<i>890,516</i>
Тайлант үеийн цэвэр ашиг	2,681,178	19,191,536	7,109,914

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (Тусдаа)

Шалгуур үзүүлэлт	Байх ёстой	2021	2022.I
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	30.7%	28.8%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	33.1%	30.9%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	31.7%	28.3%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	16.2%	10.7%
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	30%-иас хэтрэхгүй	11.7%	11.2%
ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-иас хэтрэхгүй	0.0%	0.0%
Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	25%-иас хэтрэхгүй	0.4%	0.4%
Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	10%-иас хэтрэхгүй	0.0%	0.0%
Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө	50%-иас хэтрэхгүй	8.5%	7.9%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	+/-40%-иас хэтрэхгүй	18.0%	5.3%
Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	74.7%	78.7%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	38.5%	39.1%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-иас хэтрэхгүй	0.9%	0.8%

ХУВЬЦААНЫ ХАНШ



Үнэт цаасны код	INV
Зах зээлийн үнэлгээ	285 тэрбум төгрөг
Гаргасан хувьцааны тоо ширхэг	71,727,918 ширхэг
Хаалтын ханш /2022.03.31/	3,980.0 төгрөг
IPO-с хойших өсөлт	141%

Хувьцааны ханш:

3980₮

2022.I YOY өсөлт:

25% ↑

IPO-с хойш:

141% ↑

“Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа нь МХБ-ийн ТОП-20 индекст багтдаг ба 2021 оны 9 сард хувьцааны бүртгэлийн II ангиллаас I ангилал руу ахисан амжилттай байна.